МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 22 өдөр Дугаар А/603 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Агаар орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний нэр, төсөвт өртгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг дарга дансны "Агаарын бохирдол бууруулах зардал"–аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Тус арга хэмжээний "Хоёр тарифт ухаалаг тоолуур худалдан авах" ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

4.Их-Уул сумын Их-Уул дулаан ХХК-ний халаалтын тогоонд утаа сорогч, үлээх насос худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Их-Уул сумын Засаг дарга (Б.Мянганбаяр)-д үүрэг болгосугай.

5.Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд зохион байгуулах сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011394

Аймгийн Засаг даргын 2023 оны
11. дүгээр сарын 22-өдрийн А/108 тоот
захирамжийн хавсралт

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Хоёр тарифт ухаалах тоолуур худалдан авах /Мөрөн сумын агаарын чанарын бүсэд байгаа айл өрхүүдэд олгох/.	2023	2023	20.0	20.0
2	Их-Уул сумын Их-Уул дулаан ХХК-ийн халаалтын тогоонд утаа сорогч, үлээх насос худалдан авах	2023	2023	7.0	7.0
3	Тогтвортой хөгжил ба бидний ирээдүй 2023 Олон Улсын сургалт зохион байгуулах	2023	2023	5.0	5.0
4	Агаарын бохирдол бууруулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	2023	2023	8.6	8.6
5	Нийт дүн			40.6	40.6

_____оОо_____